



Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар

“Нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны үр
дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан
/ДУА-2018-02-ГА/



**Нийтлэг үйлчилгээ
ОНӨААТҮГ нь “Аж ахуйн
тооцоот үйлдвэрийн
газар” хэлбэрээр бие даан
үйл ажиллагаа явуулах
боломжгүй байна.**

Тайланг бэлтгэсэн:	Товчилсон үгс	3
Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй Ерөнхий мэдээлэл	4 5
Дарга, тэргүүлэх аудитор П.Төвсанаа	<i>Бүлэг 1. Нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ-ын бүтэц, зохион байгуулалт оновчгүй байна..</i>	6-9
Аудитын менежер Х.Наранцацрал	1.1 Байгууллагын хариуцлагын хэлбэр оновчтой зохион байгуулагдаагүй байна.	6-8
Ахлах аудитор Ч.Бэрхсайхан	1.2 Байгууллагаас болон ТУЗ-өөс баталж мөрдөх журмыг боловсруулаагүй байна.	9
Аудитор Р.Хаш-Эрдэнэ	<i>Бүлэг 2. Нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ-ын удирдлага болон санхүүгийн үйл ажиллагаа үр ашиг муутай байна.</i>	10-12
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70593208 дугаарын утас, 70592439 дугаарын факсаар харилцана уу.	2.1 Байгууллагын үйл ажиллагаа хүртээмж муутай, дийлэнх үйл ажиллагаа нь АЗДТГ-т чиглэсэн байна.	10
	2.2 Санхүүгийн үйл ажиллагаа үр дүн муутай байна.	11-12
	Дүгнэлт	13
	Зөвлөмж	13
	Шалгагдагч байгууллагын санал, тайлбар	14
	Тайлан баталгаажуулах тушаал	15-16
	Тайлангийн хавсралтууд	17-19
ХАЯГ: Сайнцагаан сум 7-р баг, Нутгийн удирдлагын ордон, 214 тоот		
2018 оны 9 дүгээр сар		

ТОВЧИЛСОН ҮГС

ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
АЗДТГ	Аймгийн Засаг даргын Тамгын газар
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ЗДН	Засаг даргын нөөц
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/06 дугаар тушаалаар батлагдсан аудитын сэдвийн төлөвлөгөө, Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Аудитын зорилт:

“Нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны үр дүн”-д аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, илэрсэн зөрчил дутагдлыг заасан хугацаанд нь арилгуулж энэ байгууллагыг хуулийн хүрээнд, эдийн засгийн хувьд үр өгөөжтэй ажиллуулахад оршино.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийлээ. Үүнд:

- ✓ Нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ-ын бүтэц, зохион байгуулалт хууль, эрх зүйн хүрээнд байгаа эсэх;
- ✓ Нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ-ын удирдлага, санхүүгийн үйл ажиллагаа үр ашигтай байгаа эсэх.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлт:

Дараах хууль эрх зүйн актын холбогдох заалтуудыг аудитын шалгуур үзүүлэлт болгон ашиглав.

- ✓ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль;
- ✓ Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- ✓ Дундговь аймгийн ИТХТ-ийн 2013 оны 79 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Нийтлэг үйлчилгээ үйлдвэрийн газрын дүрэм”;
- ✓ Дундговь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2014 оны 232 дугаар тогтоолын 5 дугаар хавсралтаар батлагдсан “Орон нутгийн өмчийн эд хөрөнгө түрээслүүлэх журам”;
- ✓ Дундговь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 51 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Орон нутгийн өмчийн эд хөрөнгө түрээслүүлэх журам”;
- ✓ Бусад холбогдох дүрэм, журмууд.

Аудитын хамарсан хүрээ:

Аудитад “Нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ-ын 2016-2018 оны үйл ажиллагааг хамруулав.

Аудитын арга зүй:

Аудитыг төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын арга зүй, тулгуур зарчим (АДБОУС 300), гүйцэтгэлийн аудитын удирдамж (АДБОУС 3000-3100)-ийг ашиглан, журам, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэв. Аудитын арга

Аудит хийх багийн бүрэлдэхүүн, хугацаа:

зүйн дагуу холбогдох байгууллагын албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа, тодруулга авах, санхүүгийн баримт материалыг түүвэрлэн шалгах, мэдээ тайланг гаргуулж тулган баталгаажуулах, зэрэгцүүлэх, харьцуулах, ажиглалт хийх, бодит байдлыг фото зураг авч баримтжуулах зэрэг шаардлагатай горимуудыг хэрэгжүүлэн, цуглуулсан нотлох баримтад харьцуулалт, судалгаа, шинжилгээ хийж дүнг нэгтгэн боловсруулж, түүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж өглөө.

Аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг дарга, тэргүүлэх аудитор П.Төвсанаа хянан удирдаж, аудитын менежер Х.Наранцацрал үе шатны чанарын хяналт хэрэгжүүлэн, гүйцэтгэлийн аудитын албаны ахлах аудитор Ч.Бэрхсайхан, аудитор Р.Хаш-Эрдэнэ нар 2018 оны 6 дугаар сарын 04-ний өдрөөс 2018 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийг дуустал хугацаанд гүйцэтгэлээ.

Ерөнхий мэдээлэл

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн 79 дүгээр тогтоолоор АЗДТГ-ын Нийтлэг үйлчилгээний албыг “Нийтлэг үйлчилгээ, үйлдвэрийн газар” нэртэйгээр орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар болгон өөрчлөн байгуулсан.

Аймгийн төрийн захиргааны болон төсөвт байгууллагуудад эрэлт нийлүүлэлтийн шаардлагад нийцсэн чанартай бүтээгдэхүүн, үйлчилгээ үзүүлэх, ажилтан албан хаагчдыг албан үүргээ гүйцэтгэхэд нь ая тухтай орчин бүрдүүлж, үйл ажиллагаагаа жигд хүртээмжтэй шуурхай явуулах нөхцөл бололцоогоор хангах зорилготой.

Нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ-нь нийт 20 ажилтны орон тоотойгоор ажлын байрны тохижилт, цэвэрлэгээ хийх, эх бэлтгэх, хэвлэн олшруулах, хурал, сургалт, семинарын бэлтгэл зохион байгуулалт, унаа тээвэрлэлт, авто граж, аялал жуулчлал, зочид буудал, цайны газар зэрэг үйлчилгээ үзүүлж байна.

Тус газар нь 2016 онд төсвөөс 150.8 сая төгрөгийн санхүүжилт авч, өөрийн үйл ажиллагаанаас 31.7 сая төгрөгийн орлого олж, 2017 онд 155.4 сая төгрөгийн санхүүжилт авч, 28.9 сая төгрөгийн үйл ажиллагааны орлого олж, 353.6 сая төгрөгийн хандив авсан байна.

Бүлэг 1

• Нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ-ын бүтэц, зохион байгуулалт оновчгүй байна.

1.1 Байгууллагын хариуцлагын хэлбэр оновчтой зохион байгуулагдаагүй байна.

Нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ нь 2016 онд 182.6 сая төгрөгийн орлого тайлагнасны 150.8 сая төгрөг буюу 82.6 хувийг орон нутгийн төсвөөс авсан санхүүжилт, 2017 онд 536.4 сая төгрөгийн орлого тайлагнаснаас 353.6 сая төгрөг буюу 65.9 хувь нь наадам зохион байгуулах хандив, 153.4 сая төгрөг буюу 28.6 хувь нь орон нутгийн төсвөөс авсан санхүүжилт байна. /Хүснэгт 1/

Хүснэгт 1 /сая төгрөг/

Эх үүсвэр	2015	2016	2017	2018
ЗДТГ-ын төсвөөс авсан санхүүжилт	165.9	150.8	153.4	67.1
Үйл ажиллагааны орлого	37.0	31.7	28.9	38.5
Наадам зохион байгуулах хандив, санхүүжилт	18.0	15.0	353.6	
Нийт орлого	220.9	197.5	535.9	105.6

График 1



Нийт орлогын хэмжээ 2017 онд өссөн нь наадам зохион байгуулах хандив авсантай холбоотой ба үйл ажиллагааны орлого өмнөх оноос буурсан үзүүлэлттэй байна. /График 1/

Өөрийн үйл ажиллагааны орлогын нийт орлогод эзлэх хувь бага буюу өөрийгөө санхүүжүүлж, бие даан үйл ажиллагаа явуулах

боломжгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2¹, Орон нутгийн өмчит Нийтлэг үйлчилгээ үйлдвэрийн газрын дүрмийн 1.1² дэх хэсэгт заасан шаардлагыг хангахгүй байна.

¹ Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж бие даан иргэний гүйлгээнд ордог хуулийн этгээдийг аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар гэнэ.

² Дундговь аймгийн "Нийтлэг үйлчилгээ үйлдвэрийн газар" орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь орон нутгийн өмчийн өөрийн балансад бүртгэгдсэн эд хөрөнгө, дүрмээр хүлээсэн эрх, үүргийн хүрээнд, өөрийн үйл ажиллагааны орлогоор санхүүжих замаар байгууллагын эдийн засгийн үр ашиг санхүүгийн чадавхийг нэмэгдүүлэн, аймгийн төр захиргааны болон төсөвт байгууллагуудад зах зээлд нийцсэн чанартай бүтээгдэхүүн, үйлдвэрлэл үйлчилгээг гэрээгээр үзүүлэх орон нутгийн өмчит үйлдвэрийн газар юм./

Хүснэгт 2 /сая төгрөг/

№	Хөрөнгийн нэр	Хаана бүртгэлтэй	Бүртгэлийн дүн	Эх үүсвэр	
1	Өргөө	АЗДТГ	352.0		АЗДТГ-ын балансад бүртгэлтэй хөрөнгийг түрээс төлөлгүй ашиглан үйл ажиллагаа явуулж байна. /Хүснэгт 2/
2	Буудал	АЗДТГ	3,264.9		
3	Хурлын танхим	АЗДТГ	-		
4	Цайны газар	АЗДТГ	-		
5	Граш	АЗДТГ	316.0		Энэ нь Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн 51 дүгээр тогтоолын хавсралт 2-оор батлагдсан “Орон нутгийн өмчийн эд хөрөнгө түрээслүүлэх журам”-ын 1.8 ³ -д заасныг зөрчиж байна. Автомашинууд нь АЗДТГ-ын өмчлөлд байдаг боловч
6	Пургон	Нийтлэг үйлчилгээ	21.0	АЗДТГ	
7	Пургон	Нийтлэг үйлчилгээ	21.0	АЗДТГ	
8	Өвлийн нарлаг хүлэмж	Нийтлэг үйлчилгээ	644.7	ОНХС	
9	Сүм хөх бүрд	Нийтлэг үйлчилгээ	2,444.1	ОНХС	
10	Тоног төхөөрөмж	Нийтлэг үйлчилгээ	72.6	ОНХС	
11	Тавилга, тоног төхөөрөмж	Нийтлэг үйлчилгээ	132.8	АЗДТГ	
12	Тавилга, аж ахуйн эд хогшил	Нийтлэг үйлчилгээ	35.2	Орон нутгийн хөрөнгө оруулалт	
13	Тавилга, аж ахуйн эд хогшил	Нийтлэг үйлчилгээ	42.2	Хандив	
14	Тавилга, аж ахуйн эд хогшил	Нийтлэг үйлчилгээ	2.8	Өөрийн үйл ажиллагаа	

жолооч нарыг Нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ-аас томилж байна.

Хөрөнгийн өмчлөл, эзэмшилтэй холбоотой дээрх асуудлууд нь хөрөнгийн ашиглалт, хамгаалалт, үйл ажиллагааны уялдаа холбоо алдагдах эрсдэлийг бий болгож байна.

Нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ-ын 2018 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд 3,374.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгө тайлагнаснаас 3,161.4 сая төгрөгийн хөрөнгө нь ОНХС, орон нутгийн хөрөнгө оруулалтаар, 132.8 сая төгрөгийн хөрөнгө нь АЗДТГ-ын балансаас шилжүүлж авсан, 42.2 сая төгрөгийн хөрөнгө хандиваар, 2.8 сая төгрөгийн хөрөнгө өөрийн үйл ажиллагааны орлогоос бий болсон байна. /Хүснэгт 2/

Өөрийн эрхлэх үйл ажиллагааны чиглэлд хамааралгүй наадам зохион байгуулах зардалд 2016 онд ОНХС-аас 15.0 сая төгрөгийн санхүүжилт, 2017 онд 353.3 сая төгрөгийн хандив авсан байна.

Наадам зохион байгуулахтай холбоотой хандив, санхүүжилтийг Нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ-ын дансанд хүлээн авсан боловч наадмыг бие даан зохион

³ Орон нутгийн өмчит хуулийн этгээд нь өөрийн санхүүгийн тайлан балансад тусгагдсан орон нутгийн өөрийн өмчийн үл хөдлөх хөрөнгийг бусад өмчийн хуулийн этгээд, иргэдэд түрээслүүлэх төлбөрийн доод үнийг салбарын ангилал, үйл ажиллагааны чиглэлийг харгалзан доорхи байдлаар тогтооно.

байгуулаагүй буюу 2016 онд өөрийн дансанд орсон мөнгийг наадам зохион байгуулах комисст бэлнээр хүлээлгэн өгсөн, санхүүгийн тайланд тусгаагүй, 2017 онд хандивын хөрөнгийн зарцуулах зориулалт болон эрхийг аймгийн Засаг даргаас олгосон бөгөөд гэрээ байгуулаагүй байна.

Энэ нь Засаг дарга Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2⁴ дахь хэсэгт заасан хандив, тусламж авахыг зөвшөөрсөн заалтад хамаарахгүй тул наадам зохион байгуулах хандивыг Нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ-ын дансанд хүлээн авч, зарцуулсан болох нь харагдаж байна.

Нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ-ын эрхлэх асуудлын хүрээнд хамааралгүй, өөрөө үйлдвэрлэдэггүй, бие даан гүйцэтгэх боломжгүй, өөр этгээдээс худалдан авч нийлүүлэх, ашиг хүртэхгүй 92.1 сая төгрөгийн бараа, ажил, үйлчилгээний санхүүжилтийг орон нутгийн төсвийн хөрөнгөөс олгосон байна.

Тухайлбал 2016 онд ОНХО-аар 6.0 сая төгрөгийн, ЗДН хөрөнгөөс 26.5 сая төгрөгийн, 2017 онд ОНХО-аар 23.3 сая төгрөгийн, ЗДН хөрөнгөөс 21.8 сая төгрөгийн, АЗДТГ-аас 14.5 сая төгрөгийн бараа, ажил, үйлчилгээг гуравдагч этгээдээр дамжуулан гүйцэтгэсэн байна. (Хавсралт 3)

2016 оны эцэст Засаг даргын нөөц хөрөнгөөс Нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ-тай гэр нийлүүлэх, бэлэг дурсгалын зүйлс худалдан авах, ном хэвлүүлэх гэрээ байгуулан 20.6 сая төгрөгийн, 2017 оны эцэст танилцуулга хэвлүүлэх 2.0 сая төгрөгийн санхүүжилт тус тус олгосон байна.

Тус ажлуудын гэрээний хугацаа дууссан боловч ажил бүрэн хийгдээгүй, 13.2 сая төгрөгийн үлдэгдлийг Нийтлэг үйлчилгээний санхүүгийн тайланд өглөгөөр тайлагнаад хөрөнгийг өөрийн үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7⁵-д зааснаар оны эцэст төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг дээд шатны төсөвт төвлөрүүлэхээс зайлсхийж тухайн ажил, үйлчилгээг он дамжуулан гүйцэтгүүлэхээр Нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ-ын дансанд шилжүүлсэн байна.

Энэ нь төсвийн хөрөнгийг ОНӨААТҮГ-аар дамжуулан авч төсвөөс гадуур, эрх зүйн хязгаарлалт багатай хяналтгүй зарцуулах эрсдэлийг бий болгож байна.

Нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ нь хуулийн этгээдийн улсын бүртгэлд хариуцлагын хэлбэр нь ОНӨААТҮГ гэж бүртгэгдсэн боловч Татварын хэлтсийн мэдээллийн системд төсөвт байгууллагаар бүртгэгдсэн байна.

⁴ Зөвхөн дор дурдсан нийгмийн үйлчилгээ үзүүлдэг төсвийн байгууллага энэ хуульд заасан журмын дагуу хандив, тусламж авч болно: 25.2.1.эмнэлгийн үйлчилгээ; 25.2.2.бүх шатны боловсролын үйлчилгээ; 25.2.3.соёлын үйлчилгээ.

⁵ Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ.

Энэ нь Татварын хэлтсийн холбогдох албан тушаалтаны хариуцлагагүй байдалтай холбоотой ба ААНОАТ-ын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1⁶, 4 дүгээр зүйлийн 4.1.5⁷-д заасныг тус тус зөрчиж байна.

1.2 Байгууллагаас болон ТУЗ-өөс баталж мөрдөх журмыг боловсруулаагүй байна.

Дундговь аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны 79 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар Нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ-ын дүрмийг баталсан боловч дүрэмд заагдсан журмуудыг боловсруулж батлаагүй байна. /Хүснэгт 3/

Хүснэгт 3

№	Асуулт	Тийм /Үгүй	Батлах эрх бүхий субъект
1	Байгууллагын бүтэц орон тоог баталсан шийдвэр байгаа эсэх	Үгүй	ТУЗ
2	Урт хугацааны стратеги төлөвлөгөө баталсан эсэх	Үгүй	ТУЗ
3	Дотоод хяналтын журам байгаа эсэх	Үгүй	Байгууллагын дарга
4	Худалдан авалт, борлуулалтын журам байгаа эсэх	Үгүй	Байгууллагын дарга
5	Бизнес төлөвлөгөө байгаа эсэх	Үгүй	
6	Худалдан авалт, борлуулалтын төлөвлөгөө байгаа эсэх	Тийм	

ТУЗ бүтэц орон тоо, урт хугацааны стратеги төлөвлөгөө батлаагүй, байгууллагын дарга дотоод хяналтын журам, худалдан авалт борлуулалтын журам, үнэт цаас хэрэглэх журмыг боловсруулж батлаагүй, бизнес төлөвлөгөө боловсруулж ажиллахгүй байна.

Энэ нь байгууллага үйл ажиллагааг урт хугацаагаар төлөвлөхгүй, худалдан авалт, борлуулалт, үнэт цаас хэрэглэх

зохицуулалтгүй, дотоод хяналтгүй ажиллах эрсдэлийг бий болгож байна.

ТУЗ хангалтгүй ажилласан, ТУЗ-ийн ажиллах журам байхгүйтай холбоотой дээрх асуудлууд үүсч байна.

Мөн Нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ нь төсвийн байгууллагын санхүүгийн тайлангийн маягтаар санхүүгийн тайлан гаргаж байна.

Энэ нь Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар батлагдсан “Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ыг зөрчиж байна.

Өөрөөр хэлбэл бүтээгдэхүүн, үйлчилгээний өртөг тооцож, ашиг алдагдалд дүн шинжилгээ хийж ажиллахгүй байна. Энэ нь байгууллага үйл ажиллагаагаа оновчтой удирдах, төсөв санхүүг үр ашигтай төлөвлөж, зарцуулахгүй байх эрсдэлийг бий болгож байна.

⁶ Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан аж ахуйн нэгж, тэдгээрийн салбар, төлөөлөгчийн газар;

⁷ “аж ахуйн нэгж” гэж улсын бүртгэлд бүртгэгдэж, аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж байгаа компани, нөхөрлөл, хоршоо, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар, тэдгээртэй адилтгах орлогын албан татвар төлөх үүрэг бүхий хуулийн этгээдийг;

Бүлэг 2

• Нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ-ын удирдлага болон санхүүгийн үйл ажиллагаа үр ашиг муутай байна.

2.1 Байгууллагын үйл ажиллагаа хүртээмж муутай, дийлэнх үйл ажиллагаа нь АЗДТГ-т чиглэсэн байна.

Нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ 2014 онд аймгийн АЗДТГ-аас салж үйл ажиллагаа явуулж эхэлсэн боловч тус газрын ихэнхи ажил, үйлчилгээ нь бусад төсвийн байгууллагад хүрч ажиллаж чадахгүй байна.

Үйлдвэрийн газрын зорилгыг “Аймгийн төрийн захиргааны болон төсөвт албан газруудад эрэлт нийлүүлэлтийн шаардлагад нийцсэн чанартай бүтээгдэхүүн, үйлчилгээг үзүүлэх тэдгээр байгууллагуудын ажилчдын албан үүргээ гүйцэтгэхэд нь ая тухтай орчин ахуй бүрдүүлж, үйл ажиллагаагаа жигд хүртээмжтэй шуурхай явуулах нөхцөл бололцоогоор хангах.” гэж тодорхойлсон байна.

Тус зорилгын хүрээнд үзүүлж буй үйлчилгээний дийлэнх нь зөвхөн АЗДТГ-т чиглэгдсэн байна.

Тухайлбал автомашины үйлчилгээ, барилга байгууламжийн их ба урсгал засвар, тохижилт, цэвэрлэгээ хийх үйлчилгээ, авто граж, техник хэрэгслийн засварын үйлчилгээ, албан контор, үйлчилгээний барилга байгууламжийн цахилгаан дулаан, усан хангамжийн үйлчилгээ зэрэг нь зөвхөн АЗДТГ-т хамаарч байна.

Албан тоот хэвлэх үйлчилгээнд харьцангуй олон байгууллага хамрагдаж байгаа боловч тус үйлчилгээнээс орсон орлого 2016 онд 5.8 сая төгрөг буюу нийт орлогын 3.2 хувь, 2017 онд 3.7 сая төгрөг буюу нийт орлогын 2.0 хувийг эзэлж байгаа нь байгууллагын үйл ажиллагаанд үзүүлэх нөлөө бага болох нь харагдаж байна. /Хавсралт 1/

2.2 Санхүүгийн үйл ажиллагаа үр дүн муутай байна.

Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөөг баталсан боловч хэрэгжилтэд хяналт тавьж, гүйцэтгэлийг хэлэлцэн үнэлэлт, дүгнэлт өгөөгүй байна.

Зардлыг нэр төрлөөр ангилан төлөвлөсөн боловч батлуулаагүй, зардлыг төлөвлөсөн ангиллаас өөрөөр тайлагнасан.

Энэ нь зардлыг төлөвлөсний дагуу зарцуулахгүй байх үр дагаварыг бий болгож, зардлыг төлөвлөн ажилласны ач холбогдол гарахгүй байна.

2018 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлангаар мөнгөн хөрөнгийн эцсийн үлэгдэл 1.5 сая төгрөг, авлага 11.7 сая төгрөг, богино хугацаат өр төлбөр 42.7 сая төгрөг, нийт 104.2 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Хүснэгт 4 /сая төгрөг/


Үзүүлэлт/он	2015	2016	2017	2018.06
Авлага	3.8	2.4	7.2	11.7
Өр төлбөр	1.7	0.5	27.9	42.7
Ашиг/алдагдал	8.6	(27.9)	(214.7)	(104.2)
Мөнгөн хөрөнгө	8.5	22.1	4.2	1.5

Жил бүр алдагдал хүлээж, өр төлбөрийн хэмжээ нэмэгдсэн, мөнгөн хөрөнгийн үлдэгдэл буурсан зэрэг нь байгууллагын санхүүгийн үзүүлэлтүүдийн харьцаа алдагдсаныг илтгэж байна. /Хүснэгт 4/, /График 2/

Байгууллагад орон нутгийн хөгжлийн сан, хөрөнгө оруулалтаар өндөр дүнтэй үндсэн хөрөнгө бий болсноор элэгдлийн зардал өсч алдагдлын хэмжээ нэмэгдэхэд нөлөөлсөн байна.

НДШ, ХХОАТ-ын өр төлбөр жил бүр нэмэгдэж байгаа бөгөөд 2018 оны эхний хагас жилийн байдлаар НДШ-ийн өр 7.7 сая төгрөг, ХХОАТ-ын өр 12.3 сая төгрөг байна.

График 2



АЗДТГ-аас Нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ-т олгодог санхүүжилтыг 2017, 2018 онд бууруулж олгосон нь НДШ, ХХОАТ-ын өглөг үүсэхэд нөлөөлсөн байна.

Энэ нь НДШ, ХХОАТ төлөлтөөр баталгаажсан тэтгэвэр, тэтгэмж, татварын хөнгөлөлт, чөлөөлөлт, болон бусад тусламж, үйлчилгээнд ажилчин, албан хаагчид хамрагдахгүй байх үр дагавартай байна.

График 3 /сая төгрөг/



2018 оны эхний хагас жилд 11.7 сая төгрөгийн авлага тайлагнасны 5.2 сая төгрөг буюу 44.9 хувь нь 2015, 2017 онуудад, 6.4 сая төгрөг буюу 55.1 хувь нь 2018 онд үүссэн авлага байна. /График 3/

байгууллага, хувь хүн хүлээн зөвшөөрөхгүй баталгаажуулаагүй байна.

2015 онд үүссэн 4.3 сая төгрөгийн авлагыг харилцагч

байгаа тул тооцоо нийлж

Хөрөнгийг түрээсээр эзэмшүүлж олсон орлогын 20 болон 10 хувийг орон нутгийн орлогын дансанд 2016 оноос хойш төвлөрүүлээгүй, орлогын зарцуулалт, төвлөрүүлэлтийн мэдээг Орон нутгийн өмчийн газарт гаргаж өгөөгүй байна.

Энэ нь аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 232 дугаар тогтоолын 5 дугаар хавсралтаар батлагдсан “Орон нутгийн өмчийн эд хөрөнгө түрээслүүлэх журам”-ын нэг дүгээр бүлгийн 11.Б⁸(тухайн үед мөрдөгдөж байсан), Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны сарын 09 дүгээр сарын 19-ний өдрийн 51 тоот тогтоолын хавсралт 2-оор батлагдсан “Орон нутгийн өмчийн эд хөрөнгө түрээслүүлэх журам”-ын 2.7⁹-д заасныг тус тус зөрчиж байна.

Наадам зохион байгуулах ажлын санхүүгийн үйл ажиллагаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, журам, стандартыг зөрчсөн байна.

Наадам зохион байгуулах ажлын санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой дараах зөрчлүүд илэрлээ.

2016 оны наадам:

- ❖ ОНХС-аас Нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ-ын дансанд шилжүүлсэн наадам зохион байгуулах зардлыг бэлнээр авч наадам зохион байгуулах комисст хүлээлгэн өгсөн боловч бэлэн мөнгөний гүйлгээний тайланд тусгаагүй, худалдан авалт хийсэн анхан шатны баримтын бүрдэл дутуу байна.
- ❖ Наадмын тусгай зөвшөөрөл, мандатын хураамжаас орсон орлогыг харилцах дансанд тушаагаагүй, санхүүгийн тайланд тусгаагүй үнэт цаасны тооцоо хийж, тайлан мэдээ гаргаагүй, бэлнээр авч зарцуулсан.
- ❖ Наадам зохион байгуулах комисст хүлээлгэн өгсөн мөнгөний зарцуулагдаагүй үлдэгдлийг харилцах дансанд шилжүүлээгүй, кассын тайланд тусгаагүй.
- ❖ Засаг даргын нөөц хөрөнгөөс 2016 онд Хөдөлмөрийн гавъяаны улаан тугийн одонгоор шагнагдсан хүмүүст хүндэтгэл үзүүлэх зорилгоор 6.0 сая төгрөгийг Нийтлэг үйлчилгээний дансанд шилжүүлснийг бэлнээр авч, тухайн барааг нийлүүлдэггүй аж ахуйн нэгж, хувь хүнээс худалдан авалт хийж, тооцоог бэлэн мөнгөөр хийсэн байна.

2017 оны наадам:

- ❖ Наадам зохион байгуулах хандивын хөрөнгөөс 9.0 сая төгрөгөөр автомашины сэлбэг, засварын үйлчилгээ хийлгэсэн, анхан шатны баримтын бүрдэл дутуу байна.
- ❖ Наадам зохион байгуулах хандивын үлдэгдэл 2.9 сая төгрөгийг 2018 оны орон нутгийн хөрөнгө оруулалтаар нийлүүлсэн автомашины дутуу санхүүжилт, орлого багатай өрхийн хүүхдүүдийн шинэ жилийн арга хэмжээ, багийн шинэ жил зохион байгуулах зэрэг арга хэмжээнд зарцуулсан, анхан шатны баримтын бүрдэл дутуу байна.

⁸ Орон нутгийн өөрийн өмчийн хөдлөх хөрөнгийн түрээсийн төлбөрийг тогтоохдоо ашиглалт, үйлчилгээнд зарцуулах зардал болон элэгдлийн нормыг түрээслэх хугацаанд оногдуулан тооцож, түүнийг 20 хувиар нэмэгдүүлсэн дүн нь хөрөнгийн түрээсийн төлбөрийн доод хэмжээ болно.

⁹ Орон нутгийн өмчийг түрээсээр эзэмшүүлэгч хуулийн этгээд нь орон нутгийн өмчийг түрээсээр эзэмшүүлж олсон орлогын 90 хувийг Байгууллагын өөрийн орлогод төвлөрүүлнэ. Тус орлогын 10 хувийг Төрийн сангийн Хөрөнгө борлуулсны орлогын дансанд сар тутам төвлөрүүлнэ. Орлогын зарцуулалт, төвлөрүүлэлтийн мэдээг улирал болгоны сүүлийн сарын 25-ны дотор Орон нутгийн өмчийн газарт гаргаж өгнө.

Наадам зохион байгуулах үйл ажиллагаа нь тус байгууллагын эрхлэх үйл ажиллагааны чиглэлд хамааралгүй ба аймгийн Засаг дарга, ЗДТГ зарцуулалтыг хийсэн байна.

Нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ-ын хууль эрх зүйн зөрчилтэй байдал, өөрийн орлогоор өөрийгөө санхүүжүүлдэггүй, дийлэнх үйл ажиллагаа АЗДТГ-т чиглэсэн, хараат бусаар, бие даан үйл ажиллагаа явуулахгүй байгаа, өр, авлагыг зохистой удирдаагүй, санхүүгийн үзүүлэлтүүдийн харьцаа алдагдсан зэргээс тус байгууллага нь аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар хэлбэрээр үйл ажиллагаа явуулах боломжгүй байна.

Иймд Нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ-ыг татан буулгаж, аймгийн ЗДТГ-ын харъяанд ажиллуулах саналыг аймгийн ИТХ-аар хэлэлцүүлж, шийдвэрлүүлэх талаар аймгийн Засаг даргад зөвлөмж хүргүүлээ.

Дүгнэлт

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

Нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ-ын бүтэц, зохион байгуулалт оновчгүй байна.

- Байгууллагын хариуцлагын хэлбэр оновчтой зохион байгуулагдаагүй байна.
- Байгууллагаас болон ТУЗ-өөс баталж мөрдөх журмыг боловсруулаагүй байна.

Нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ-ын удирдлага болон санхүүгийн үйл ажиллагаа үр ашиг муутай байна.

- Байгууллагын үйл ажиллагаа хүртээмж муутай, дийлэнх үйл ажиллагаа нь АЗДТГ-т чиглэсэн байна.
- Санхүүгийн үйл ажиллагаа үр дүн муутай байна.

Зөвлөмж

Аудитаар илрүүлсэн зүйл, аудитын дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан байгууллага, албан тушаалтанд зөвлөж байна.

Аймгийн Засаг даргад:

1. Нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ-ыг татан буулгаж, аймгийн ЗДТГ-ын харъяанд ажиллуулах саналыг аймгийн ИТХ-аар хэлэлцүүлж, шийдвэрлүүлэх. Төрийн аудитын тухай хуулийн 19.3.1-д заасны дагуу тайлангийн төслийг аймгийн Засаг дарга, Нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ-т хүргүүлж, санал тайлбар авлаа.

Аймгийн Засаг дарга заасан хугацаанд хариу ирүүлээгүй тул санал тайлбаргүй гэж үзлээ. Нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ-аас дараах санал тайлбар ирүүлсэн.

Шалгагдагч байгууллагын санал, тайлбар

**ДУНДГОВЬ АЙМГИЙН
НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭ, ҮЙЛДВЭРИЙН
ГАЗАР**

212700 Мандалговь, Дундговь аймаг,
Утас: (01-592), 7059-30-00
И-мэйл: dundgovi.onuyg@gmail.com

БД 18-09-14 № 62

танай _____-ны № _____-т


Г ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Дундговь аймгийн дахь Төрийн аудитын газрын ОНӨНҮҮГазрын үйл ажиллагааны үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлд дараах саналуудыг хавсралтаар хүргүүлэв.

Санал хүсэлт

1. АИТХ-н тэргүүлэгчдийн 2014 оны 5-р сарын 14-ны 160-р тогтоолоор аж ахуйн тооцоотой ОНӨНҮҮГ нь батлагдаж улмаар АЗДТГ-тай бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээгээр 12.669.400 төгрөгний санхүүжилт тогтмол олгож байсан. 2017-2018 ондуудад ОНӨНҮҮГазрын санхүүжилтыг хасаж 9800.000 төгрөгний санхүүжилт олгосноор НДШ,ХАОАТ-т өртэй болсон

Хавсралт-1 хуудас

ДАРГА  Б.НАРАНЦЭЦЭГ

Р. Бүрхсайраг
Аудитын газрын дарга

Санал тайлбарыг авч тайлангийн 2-р бүлгийн 2 дахь хэсэг /хуудас 11/-т “АЗДТГ-аас Нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ-т олгодог санхүүжилтыг 2017, 2018 онд бууруулж олгосон нь НДШ, ХХОАТ-ын өглөг үүсэхэд нөлөөлсөн байна.” гэж нэмж орууллаа.

Тайлан баталгаажуулсан тушаал



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2018 оны 09 сарын 26 өдөр

Дугаар А/20


Мандалговь

Г Гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулах тухай Г

Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2017 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн А/188 дугаар тушаалын 6 дугаар хэсгэрлэлийн 1.2, 2.4, Гүйцэтгэлийн аудитын журмын 12 дугаар зүйлийн 12.40, Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журмын 4.2-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан /ДУА-2018-02-ГА/-г баталсугай.
2. Аудитаар илэрсэн зөрчлийн жагсаалт (акт, зөвлөмж)-ыг хэвсрэлтээр баталсугай.
3. “Нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ, Засаг даргад тус тус хүргүүлсүгэй.
4. Гүйцэтгэлийн аудитаар илэрсэн зөрчлүүдийг арилгаж, төлбөрийн акт, зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангуулан, үр дүнгийн талаар 2018 оны 11 дүгээр сарын 25-ны дотор Төрийн аудитын газарт хариу ирүүлэхийг аймгийн Засаг дарга /О.Бат-Эрдэнэ/, Нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ-ын дарга /Б.Нарацэцэг/-т тус тус зөвлөсүгэй.
5. Аудитаар өгсөн зөвлөмж, төлбөрийн актын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2018 оны 4 дүгээр улиралд гарган танилцуулахыг аудитын менежер /Х.Наранцацрал/, Гүйцэтгэлийн аудитын албаны ахлах аудитор /М.Бэрхсайхан/ нарт үүрэг болгосугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.ТӨВСАНАА



000000058

Аудитаар илрүүлсэн зөрчлийн жагсаалт

Аудитын код: ДУА-2018-02-ГА

Аудитын нэр: “Нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны үр дүн”



№	Зөрчлийн товч утга	Зөрчигдсэн хуулийн заалт	Зөрчлийн дүн сая. төг	Үүнээс				Үр өгөөжийн	
				Аудитын явцад барагдуулсан	Акт тавигдсан	Албан шаардлага өгсөн	Зөвлөмжөөр өгсөн	Тоо	Мөнгөн дүн
1	АЗДТГ балансад бүртгэлтэй хөрөнгийг түрээс төлөлгүй ашиглан үйл ажиллагаа явуулж байна.	Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн 51 тоот тогтоолын хавсралт 2-оор батлагдсан “Орон нутгийн өмчийн эд хөрөнгө түрээслүүлэх журам”-ын 1.8	-						-
2	Өөрийн эрхлэх үйл ажиллагаанд хамааралгүй наадам зохион байгуулах хандив, санхүүжилт авч, зарцуулалт болон зохион байгуулалтын ажлыг бие даан гүйцэтгээгүй. Зарим орлого, зарлагыг санхүүгийн тайлан, кассын тайланд тусгаагүй, үнэт цаасны тооцоо хийж баталгаажуулаагүй, хандивыг зориулалт бусаар зарцуулсан, анхан шатны баримтын бүрдэл дутуу.	Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4.2, 14.4.5, 14.4.6	-						-
3	Татварын мэдээллийн системд Нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ нь төсөвт байгууллагаар бүртгэгдсэн.	Татварын хэлтсийн холбогдох албан тушаалтаны хариуцлагагүй байдалтай холбоотой ба ААНОАТ-ын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 4 дүгээр зүйлийн 4.1.5	-						-
4	Нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ нь төсвийн байгууллагын санхүүгийн тайлангийн маягтаар санхүүгийн тайлангаа гаргаж, өртөг, ашгийг тооцож ажиллахгүй байна.	Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар батлагдсан “Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”	-						-
5	Байгууллагын дүрэмд заасан бүтэц орон тоо, урт хугацааны стратеги төлөвлөгөө, дотоод хяналтын журам, худалдан авалт, борлуулалтын журам, үнэт цаас хэрэглэх журмыг боловсруулж батлаагүй.	Байгууллагын дүрмийн 6.1.5.9	-						-
6	Анхан шатны баримтын бүрдэл дутуу, хүчин төгөлдөр бус баримтаар гүйлгээ хийж тайлагнасан.	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1, 13.4, 13.5, 13.6, 13.7, 14.4.2, 14.4.5, 14.4.6	-						-
7	АЗДТГ-тай өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамааралгүй, өөрөө үйлдвэрлэдэггүй, бие даан гүйцэтгэх боломжгүй, өөр этгээдээс худалдан авч нийлүүлэх, ашиг хүртэхгүй ажилд гэрээ байгуулан гүйцэтгэсэн. Төсвийн зарцуулалтыг бэлэн мөнгөөр гүйцэтгэсэн боловч ажил гүйлгээг кассын тайланд тусгаагүй.	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1, 13.4, 13.5, 13.6, 13.7, 14.4.2, 14.4.5, 14.4.6	-						-
8	Орон нутгийн өмчийн эд хөрөнгө түрээслүүлсэний орлогоос төсөвт төвлөрүүлэх орлогыг төвлөрүүлээгүй	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 232 тоот тогтоолын 5-р хавсралтын 2.7-д, 2017 оны 51 тоот тогтоолын 1-р хавсралтын 2.7-д	5.1		5.1				5.1
Дүн			5.1	-	5.1	-	-	-	5.1

Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар

ТАЙЛАН БИЧСЭН:

АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



Ч.БЭРХСАЙХАН
Р.ХАШ-ЭРДЭНЭ

ТАЙЛАНГ ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР



Х.НАРАНЦАЦРАЛ

Хавсралт №1

Орлогын задаргаа

/сая төгрөгөөр/

№	Орлогын төрөл	2015 он	2016 он	2017 он	2018.06
1	Туслах үйл ажиллагааны орлого	165.9	150.8	153.4	57.2
2	Хэвлэлийн үйлчилгээ	2.9	5.8	3.3	2.2
3	Түрээсийн орлого	7.4	12.3	7.8	1.7
4	Барааны үнэ	0.7	0.1	0.1	-
5	Сүм хөх бүрд орлого	-	-	0.4	-
6	Буудлын орлого	5.8	8.1	5.4	2.1
7	Грашийн төлбөр	0.3	1.2	0.6	-
8	Заалны төлбөр	2.4	1.2	3.4	0.3
9	Өргөөний төлбөр	0.9	0.9	1.2	0.4
10	Пургон машины төлбөр	1.5	2.2	2.0	-
11	Торгуулийн орлого	-	-	0.4	-
13	Үнэ төлбөргүй авсан орлого	18.3	-	-	-
14	Цайны газар орлого	-	-	-	21.7
15	Тоног төхөөрөмж түрээс	-	-	-	0.2
16	Даатгалын нөхөн төлбөр	-	-	2.4	5.1
17	Гэрээний ажил	-	-	-	12.7
18	Хүүгийн орлого			0.1	
	Дүн	206.0	182.6	180.3	103.7

Хавсралт №2

Зардлын задаргаа

/сая төгрөгөөр/

Зардлын эдийн засгийн ангилал	2016 он	2017 он		2018 он
		Хандивын зардал	Үйл ажиллагааны зардал	
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	119.5	-	111.9	54.4
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	9.2	-	26.8	7.2
Ашиглалтын зардал	0.3	-	0.3	3.2
Хангамжийн зардал	7.2	140.0	20.1	39.9
Нормативт зардал	0.3	0.3	0.0	-
Эд хогшил урсгал засварын зардал	9.7	1.5	0.4	0.2
Томилолт зочны зардал	0.4	21.8	5.2	0.3
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж	11.3	113.0	53.7	0.4
Аадаа үеэ-еэүүй еэ аопаа цадааё	25.0		0.7	-
Аопаа оопааё ө еэæççýã	6.0	27.3	2.5	0.7
Нийт зардал	189.0	303.9	221.7	106.3
Хөрөнгийн зардал	0.5	42.2	2.0	-
Нийт дүн	189.5	346.1	223.7	106.3

Хавсралт №3

Өөрийн эрхлэх үйл ажиллагаанд хамааралгүй, ашиггүй ажилласан ажил үйлчилгээ

/сая төгрөгөөр/

	Гүйлгээний утга	Эх үүсвэр	Орлогын дүн	Тайлбар
2016 он	"Хөдөлмөрийн гавъяаны улаан тугийн одон гардуулах" захирамж 298	ЗДН	5.9	Өөр компаниас худалдан авалт хийж ажлыг гүйцэтгэсэн. Ашиггүй ажилласан.
	Гэр худалдан авах- захирамж 473	ЗДН	6.0	Өөр компаниас худалдан авалт хийж ажлыг гүйцэтгэсэн. Ашиггүй ажилласан.
	Бэлэг дурсгалын бүтээгдэхүүн худалдан авах- захирамж 475	ЗДН	9.1	Ажил гүйцэтгэх гэрээний хугацаа дууссан ч АЗДТГ ажлаа бүрэн гүйцэтгүүлээгүй. Үлдэгдэл төсөв нь Нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ-ын санхүүгийн тайланд өглөгөөр тусгагдсан.
	Ном, мөрийн хөтөлбөр хэвлүүлэх- захирамж 474	ЗДН	5.5	Ажил гүйцэтгэх гэрээний хугацаа дууссан ч АЗДТГ ажлаа бүрэн гүйцэтгүүлээгүй. Үлдэгдэл төсөв нь Нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ-ын санхүүгийн тайланд өглөгөөр тусгагдсан.
	Сүм хөх бүрд тавилга тоног төхөөрөмж нийлүүлэх	ОН ХО	6.0	Өөр компаниас худалдан авалт хийж ажлыг гүйцэтгэсэн. Ашиггүй ажилласан.
2017 он	Үндсэн хууль баталсан хүмүүст бэлэн мөнгө тараасан	ЗДН	7.0	АЗДТГ Нийтлэг үйлчилгээний өөр ажил гүйцэтгэх төсвөөс зээлж буцааж бэлнээр төлсөн.
	Үндсэн хууль баталсан хүмүүст	ЗДН	1.0	АЗДТГ Нийтлэг үйлчилгээний өөр ажил гүйцэтгэх төсвөөс зээлж буцааж бэлнээр төлсөн.
	АЗДТГ телевизийн тайз	ЗДН	2.0	АЗДТГ Нийтлэг үйлчилгээний өөр ажил гүйцэтгэх төсвөөс зээлж буцааж бэлнээр төлсөн.
	Тавилга, тоног төхөөрөмж нийлүүлэх	ОН ХО	15.9	Өөр компаниас худалдан авалт хийж ажлыг гүйцэтгэсэн. Ашиггүй ажилласан.
	Сүм хөх бүрд тохижилтын ажил	ОН ХО	7.4	Өөр компаниас худалдан авалт хийж ажлыг гүйцэтгэсэн. Ашиггүй ажилласан.
	Бичиг хэрэг, засварын материал нийлүүлэх	АЗД ТГ	14.5	Өөр компаниас худалдан авалт хийж ажлыг гүйцэтгэсэн. Ашиггүй ажилласан.
	Танилцуулга хэвлүүлэх- захирамж 485	ЗДН	2.0	Өөр компаниас худалдан авалт хийж ажлыг гүйцэтгэсэн. Ашиггүй ажилласан.
	Төрийн албан хаагчдын зөвлөгөөн	ЗДН	9.8	Өөр компаниас худалдан авалт хийж ажлыг гүйцэтгэсэн. Ашиггүй ажилласан.
Дүн			92.1	